

САНГИЙН САЙД, САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГЫН
ХАМТАРСАН ТУШААЛ

2015 оны 12 сарын 9 өдөр

Дугаар 328./336.

Улаанбаатар хот

Заавар, дансны жишиг жагсаалт
батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2, 53 дугаар зүйлийн 53.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.2, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, нягтлан бодох бүртгэл хөтлөх, цэвэр хөрөнгийг үнэлэх заавар”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Хөрөнгө оруулалтын сангийн дансны жишиг жагсаалт”-ыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү зааврыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтийн талаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж, хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн бодлогын газар /Х.Пүрэвсүрэн/, Санхүүгийн зохицуулах хорооны Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/-т тус тус үүрэг болгосугай.



Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын:
2015 оны 12 дугаар сарын 9-ны өдрийн 2015/12/9 тоот
хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт

**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
БЭЛТГЭХ, НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ, ЦЭВЭР
ХӨРӨНГИЙГ ҮНЭЛЭХ ЗААВАР**

А-1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Санхүүгийн зохицуулах хорооноос (цаашид Хороо гэх) тусгай зөвшөөрөл авч, бүртгүүлсэн хөрөнгө оруулалтын сан нь энэхүү нягтлан бодох бүртгэлийн зааврыг үндэслэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэнэ.
- 1.2. Энэхүү заавар нь Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх), Монгол улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн бөгөөд энэ журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг зөвхөн Хороо шийдвэрлэнэ.
- 1.3. Энэхүү зааварт тулгуурлан хөрөнгө оруулалтын сан дотооддоо СТОУС болон Монгол улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөнө.
- 1.4. Хөрөнгө оруулалтын сангийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн баримт, маягт, санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, энэхүү заавар, сангийн нягтлан бодох бүртгэлийн дотоод бодлого, журамд заасны дагуу бүрдүүлж, таван жилээс доошгүй хугацаанд хадгална.
- 1.5. Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан аж ахуйн нэгжид мөрдөх санхүүгийн тайлангийн маягт загвараар үнэн зөв бэлтгэж, хуулинд заасан хугацаанд багтаан тайлагнана.
- 1.6. Хамтын хөрөнгө оруулалтын сан нь 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн дансны үлдэгдлийн жагсаалтыг сараар бэлтгэж, дараа сарын 10-ны дотор Хороонд хүргүүлнэ.
- 1.7. Хувийн хөрөнгө оруулалтын сан нь 2 дугаар хавсралтын дагуу бэлтгэсэн дансны үлдэгдлийн жагсаалтыг улирлаар бэлтгэж, дараа улирлын эхний сарын 20-ны дотор Хороонд хүргүүлнэ.
- 1.8. Аудитаар баталгаажуулсан жилийн санхүүгийн тайланг дор дурдсан байдлаар нийтэд болон нэгж эрх эзэмшигчдэд толилуулна:
 - Хороонд болон хөрөнгө оруулалтын сангийн төлөөлөн удирдах зөвлөлд хүргүүлэх;
 - Хорооны болон өөрийн цахим хуудсанд байршуулах замаар нийтэд хүргүүлэх;
 - Монгол, англи хэл дээр бэлдсэн тайланг хэвлэмэл хэлбэрээр нэгж эрх эзэмшигчид авч танилцах боломжтой байх.

А-2. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

- 2.1. Санхүүгийн тайлангийн зорилго нь хэрэглэгчдийг эдийн засгийн шийдвэр гаргахад зориулан байгууллагын санхүүгийн байдал (хөрөнгө, өр төлбөр, эздийн өмч), санхүүгийн үр дүн (ашиг, алдагдал), мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тухай мэдээллээр хангахад оршино.
- 2.2. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ дараах ерөнхий зарчмуудыг баримтална. Үүнд:

- а) Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг мөрдөх. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналд СТОУС-ыг мөрдөнө.
- б) Нягтлан бодох бүртгэлийн суурь. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэлийг аккруэл сууриар хөтөлнө. Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурь гэж мөнгө хүлээн авсан эсхүл төлсөн эсэхээс үл хамааран орлогыг олсон тухай бүрт нь хүлээн зөвшөөрч бүртгэх аргыг хэлнэ.
- в) Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтийн нэгж нь Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох төгрөг, мөнгө байна.
- г) Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг тууштай мөрдөх. Хөрөнгө оруулалтын сангийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлагналд баримталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, зарчмыг тууштай мөрдөнө.
- д) Үнэн зөв толилуулга. Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна. Санхүүгийн тайланд тоон болон чанарын үзүүлэлтүүдийг харгалзан, шаардлагатай бол нэмэлт тайлбар, тодруулгуудыг бэлтгэнэ.
- е) Хэлбэрээс агуулгыг илүүтэй анхаарах. Аливаа мэдээлэлд ажил гүйлгээ, үйл явдлыг зохих ёсоор тусгахын тулд мэдээллийн агуулга, бодит байдлыг харгалзан үзсэний үндсэн дээр бүртгэнэ.
- ё) Иж бүрэн байдал. Санхүүгийн тайланд тусгагдах мэдээллийн найдвартай байдлыг хангахын тулд мэдээллийг иж бүрнээр нь тусгана.
- ж) Тасралтгүй байх зарчим. ХОМК нь хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайланг бэлтгэх явцад сангийн үйл ажиллагаа тасралтгүй явагдах чадварт үнэлэлт дүгнэлт өгнө. Хөрөнгө оруулалтын санг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоох шийдвэр гараагүй тохиолдолд тасралтгүй байх зарчмын дагуу санхүүгийн тайланг тасралтгүй бэлтгэнэ.
- з) Илэрхийллийн тогтвортой байдал. Хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаанд гарсан томоохон хэмжээний өөрчлөлтөөс бусад тохиолдолд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийн илэрхийлэл болон түүний ангиллыг нэг тайлант үеэс нөгөө тайлант үед өөрчлөхгүй.
- и) Санхүүгийн мэдээлэл харьцуулагдахуйц байх. Санхүүгийн тайлангийн тоон мэдээллийг арга зүйн хувьд тайлант хугацааны тоо мэдээллийг өмнөх тайлант хугацааны мэдээлэлтэй харьцуулж бэлтгэнэ.
- й) Цаг хугацаандаа байх зарчим. Энэ нь хэрэглэгчдийн шийдвэрт нөлөөлөх боломжтой хугацаанд болон хуулиар заасан хугацаанд багтаан санхүүгийн тайланг бэлтгэж толилуулахыг ойлгоно.
- к) Цэвэр дүн гаргах. СТОУС-д шаардсан эсхүл зөвшөөрсөнөөс бусад тохиолдлуудад хөрөнгө ба өр төлбөр, орлого болон зардлыг нэгтгэж, цэвэр дүнгээр тайлагнахгүй.

А-3. ДАНСНЫ ЖИШИГ ЖАГСААЛТ

- 3.1. Дансны нэгдсэн жагсаалт нь мэргэжлийн байгууллагын үйл ажиллагааны онцлогийг бүрэн тусгасан, нягтлан бодох бүртгэлээр дамжуулан хүлээн авах мэдээллийн хэрэгцээг бүрэн хангахуйц бүртгэлийн үйл ажиллагааг СТОУС-ын жишгийн дагуу ангилсан дансны нэр болон дугаараас бүрдсэн системчилсэн жагсаалт байна.

- 3.2. Дансны дугаар хэдэн оронтой байх нь тухайн байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, удирдлагын мэдээллийн хэрэгцээнээс хамаарна.
- 3.3. Дансдыг кодчилах аргачлал нь улсын хэмжээнд нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх зорилгод нийцсэн байна.
- 3.4. Хөрөнгө оруулалтын сан нь 2 дугаар хавсралтанд заасан дансны үлдэгдлийн жагсаалтыг үндэс болгон өөрийн үйл ажиллагаа, хэлбэр, зохион байгуулалтын онцлогийг тусгасан дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж, дотооддоо мөрдөнө.

Б. ХӨРӨНГӨ

Тодорхойлолт

Хөрөнгө гэдэг нь хөрөнгө оруулалтын сангийн хяналтанд байгаа бөгөөд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүсч, ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх нөөц юм.

Ангилал

Санхүүгийн тайланд хөрөнгийг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө
- Бусдаас авах авлага
- Урвуу репо
- Татварын авлага
- Үнэт цаас
- Барьцаанд тавьсан үнэт цаас
- Дериватив хөрөнгө
- Урьдчилж төлсөн тооцоо
- Бусад эргэлтийн хөрөнгө
- Хойшлогдсон татварын хөрөнгө
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө
- Бусад эргэлтийн бус хөрөнгө

Хүлээн зөвшөөрөх

Хөрөнгийн хувьд ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх магадлалтай бөгөөд өртгийг бодитой тооцох боломжтой үед хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Данснаас хасах

Хөрөнгийн бүх эрсдэл, өгөөжийг бусдад шилжүүлсэн эсхүл хөрөнгийн ашиглалтаас ирээдүйн эдийн засгийн үр өгөөж хүртэхгүй болсон үед хөрөнгийг данснаас хасч, бүртгэнэ.

Үнэлгээ, хэмжислт

Хөрөнгийн анхны өртөг нь тухайн хөрөнгийг олж авсан буюу худалдан авч бэлтгэсэн өдрийн бодит үнэ цэнээр тодорхойлогдоно. Хөрөнгийн дараа үеийн үнэлгээ буюу санхүүгийн тайланд толилуулах дүн нь түүний ангиллаас шалтгаалан ялгаатай зарчмаар илэрхийлэгдэнэ.

Б.1. МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Хамрагдах зүйлс

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө гэж үнэ цэнийн өөрчлөлтөөс өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, түргэн борлогдох чадвартай хөрөнгийг хэлнэ. Үүнд касс дахь бэлэн мөнгө, банкин дахь харилцах, хадгаламж, мөнгөтэй адилтгах бусад хөрөнгүүд багтана.

Үнэлгээ, хэмжилт

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн хүлээн зөвшөөрөх ба төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Тайлагналын өдөр гадаад валютыг тухайн өдрийн албан ханшаар дахин үнэлэх ба ханшийн тэгшитгэлээр үүссэн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн тайланд толилуулах

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө”-өөр 1.1.1 дүгээр мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хотлолт

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн орлогын гүйлгээ хийхэд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Холбогдох данс

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн зарлагын гүйлгээ хийхэд:

Дебет: Холбогдох данс
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн тэгшитгэлээр гадаад валютын ханш өссөн бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн тэгшитгэлээр гадаад валютын ханш буурсан бол:

Дебет: Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Б.2. БУСДААС АВАХ АВЛАГА

Тодорхойлолт

Авлага гэж нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний үнэ эсхүл бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн хөрөнгийн дүнг хэлнэ. Бусдаас авах авлагад ХОМК-аас авах авлага, кастодианаас авах авлага, ногдол ашгийн авлага, хүүгийн авлага, бусад авлага багтана. Харин татварын авлагыг тусад нь толилуулна.

Үнэлгээ, хэмжилт

Авлагыг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна. Авлагын хорогдуулсан өртөг гэж анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс эргэн төлөлт болон эрсдэлийн санг хассан цэвэр дүнг хэлнэ.

Бусдаас авах авлагын хугацаа, эргэн төлөлт, бусад үзүүлэлтийг харгалзан үзэж, СТОУС-д нийцүүлэн эрсдэлийн сан байгуулна.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн авлагыг Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгт хөрвүүлэн хүлээн зөвшөөрөх ба төгрөг, валютаар давхар бүртгэнэ. Тайлагналын өдөр гадаад валютыг тухайн өдрийн албан ханшаар дахин үнэлэх ба ханшийн тэгшитгэлээр үүссэн зөрүүг тайлант хугацааны орлого, зардлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн тайланд толилуулах

Бусдаас авах авлагыг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Дансны авлага”-аар 1.1.2 дугаар мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Авлагыг хүлээн зөвшөөрч, бүртгэхэд:

Дебет: Бусдаас авах авлагын данс
Кредит: Холбогдох данс

Авлага төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Бусдаас авах авлагын данс

Авлагад эрсдэлийн сан байгуулахад:

Дебет: Эрсдэлийн сангийн зардал
Кредит: Авлагын эрсдэлийн сангийн данс

Авлагын эрсдэлийн сангаас авлагыг хаасан бол:

Дебет: Авлагын эрсдэлийн сангийн данс
Кредит: Бусдаас авах авлагын данс

Б.3. УРВУУ РЕПО

Тодорхойлолт

Урвуу репо нь эргүүлэн худалдах нөхцлөөр худалдан авсан санхүүгийн хэрэгслийг хэлнэ.

Үнэлгээ, хэмжилт

Урвуу репог анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна. Хорогдуулсан өртөг гэж анх хүлээн зөвшөөрсөн дүнгээс эргэн төлөлт болон эрсдэлийн санг хассан цэвэр дүнг хэлнэ.

Эргүүлэн худалдах нөхцлөөр худалдан авсан санхүүгийн хэрэгслийг тэнцлийн гадуурх дансанд бүртгэх ба урвуу репо төлөгдөхөд зарлагадана. Хэрэв урвуу репо төлөгдөхгүй бол уг санхүүгийн хэрэгслийг тэнцэлд бүртгэж, урвуу репогийн дансыг кредитлэнэ.

Санхүүгийн тайланд толилуулах

Урвуу репог санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа хугацааг харгалзана. Урвуу репо нэг жил хүртэлх хугацаатай бол “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Бусад санхүүгийн хөрөнгө”-өөр 1.1.5 дугаар мөрөнд толилуулна. Нэг жилээс дээш хугацаатай бол “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Бусад эргэлтийн бус хөрөнгө”-өөр 1.2.8 дугаар мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Урвуу репог худалдан авахад:

Дебет: Урвуу репо
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Урвуу репогийн хүүг хуримтлуулан тооцоолж, бүртгэхэд:

Дебет: Холбогдох хуримтлуулж тооцсон хүүгийн авлага
Кредит: Хүүгийн орлого

Хуримтлуулсан хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Холбогдох хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Урвуу репо эргэн төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Урвуу репо

Хэрэв репо гаргасан этгээд гэрээт хугацаандаа үнэт цаасаа эргүүлэн аваагүй, түүнд бодогдсон хүүг төлөөгүй нөхцөлд хөрөнгө оруулалтын сан нь барьцааны үнэт цаасыг өмчлөх эрх үүснэ:

Дебет: Үнэт цаасны холбогдох данс

Кредит: Урвуу репо

Урвуу репо хэрэгсэлд эрсдэлийн сан байгуулсан бол:

Дебет: Эрсдэлийн сангийн зардал

Кредит: Урвуу репогийн эрсдэлийн сангийн данс

Эрсдэлийн сангаас урвуу репог хаасан бол:

Дебет: Урвуу репогийн эрсдэлийн сангийн данс

Кредит: Урвуу репо

Б.4. ҮНЭТ ЦААС

Хамрагдах зүйлс

Үнэт цаасыг түүний төрлөөр ангилж, бүртгэнэ. Тухайлбал: Засгийн газрын өрийн хэрэгсэл, Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэл, аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл, хувьцаат компанийн хувьцаа, компанийн өрийн хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гэх мэт.

Хэрэв үнэт цаасыг барьцаанд тавьсан бол санхүүгийн хөрөнгийн ангиллыг өөрчилж, “Барьцаанд тавьсан үнэт цаас”-аар харуулна.

Үнэлгээ, хэмжилт

Үнэт цаасыг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр үнэлж, толилуулна. Өөрөөр хэлбэл санхүүгийн хэрэгслийг бодит үнэ цэнээр илэрхийлж, бүртгэх ба бодит үнэлгээнд гарсан аливаа өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд хүлээн зөвшөөрнө.

Урт хугацаат үнэт цаасны хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолж, хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн тайланд толилуулах

Үнэт цаасыг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа хугацаа, зорилгыг харгалзана. Үнэт цаасыг нэг жил хүртэлх хугацаанд эзэмших эсхүл арилжааны зориулалттай бол “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Бусад санхүүгийн хөрөнгө”-өөр 1.1.5 дугаар мөрөнд толилуулна. Нэг жилээс дээш хугацаагаар эзэмших үнэт цаасыг “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Урт хугацаат хөрөнгө оруулалт”-аар 1.2.4 дүгээр мөрөнд толилуулна.

Эзэмшиж буй үнэт цаасаа нэг жил хүртэлх хугацаанд барьцаанд тавьсан бол “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Бусад эргэлтийн хөрөнгө”-өөр 1.1.8 дугаар мөрөнд, нэг жилээс дээш хугацаагаар барьцаанд тавьсан бол “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Бусад эргэлтийн бус хөрөнгө”-өөр 1.2.8 дугаар мөрөнд толилуулна. Түүнчлэн барьцаанд тавьсан үнэт цаасны талаар санхүүгийн тайлангийн тодруулгын “Бусад эргэлтийн бус хөрөнгө” хэсэгт тайлбарлаж, тодруулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Үнэт цаасыг худалдан авахад:

Дебет: Үнэт цаасны холбогдох данс
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Өрийн хэрэгслийн хүүг хуримтлуулан тооцоолж, бүртгэхэд:

Дебет: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага
Кредит: Хүүгийн орлого

Хуримтлуулсан хүү төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага

Өмчийн хэрэгсэлд зарласан ногдол ашгийг хуримтлуулан тооцоолж, бүртгэхэд:

Дебет: Ногдол ашгийн авлага
Кредит: Ногдол ашгийн орлого

Ногдол ашиг төлөгдөхөд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Ногдол ашгийн авлага

Үнэт цаасыг дахин үнэлж, бодит үнэ цэнээр илэрхийлэх үед бодит үнэ цэн нь бүртгэсэн үнээс илүү байвал нэмэгдүүлэх дүнгээр:

Дебет: Үнэт цаасны холбогдох данс
Кредит: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний олз

Үнэт цаасыг дахин үнэлж, бодит үнэ цэнээр илэрхийлэх үед бодит үнэ цэн нь бүртгэсэн үнээс бага байвал бууруулах дүнгээр:

Дебет: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний гарз
Кредит: Үнэт цаасны холбогдох данс

Үнэт цаасыг бүртгэлд тусгасан үнээс дээгүүр үнээр худалдан борлуулж, арилжаа ашигтай хийгдсэн үед:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Үнэт цаасны холбогдох данс
Кредит: Санхүүгийн хэрэгслийн арилжааны олз

Үнэт цаасыг бүртгэлд тусгасан үнээс доогуур үнээр худалдан борлуулж, арилжаа алдагдалтай хийгдсэн үед:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Дебет: Санхүүгийн хэрэгслийн арилжааны гарз
Кредит: Үнэт цаасны холбогдох данс

Үүний зэрэгцээ өмнө нь бүртгэсэн үнэт цаасны үнэлгээний хэрэгжээгүй олз, гарзыг хэрэгжсэн олз, гарз буюу арилжааны олз, гарз болгон тохируулна.

Дахин үнэлгээний үр дүнд цэвэр гарзыг тодорхойлж бүртгэсэн үнэт цаасны хувьд:

Дебет: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний гарз
Кредит: Санхүүгийн хэрэгслийн арилжааны олз

эсхүл

Дахин үнэлгээний үр дүнд цэвэр олзыг тодорхойлж бүртгэсэн үнэт цаасны хувьд:

Дебет: Санхүүгийн хэрэгслийн арилжааны гарз
Кредит: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний гарз

Б.5. ҮҮСМЭЛ САНХҮҮГИЙН ХЭРЭГСЭЛ БУЮУ ДЕРИВАТИВ

Тодорхойлолт

Дериватив (үүсмэл санхүүгийн хэрэгсэл) гэж суурь хүчин зүйлийн үнээс хамаарч үнэлгээ нь өөрчлөгддөг, ирээдүйд хэрэгжих нөхцөлтэй бөгөөд анхны хөрөнгө оруулалт багатай эсхүл шаардлаггүй байдаг гэрээ, хэлцлийг хэлнэ. Үүнд форвард, фьючерс, своп, опцион хэрэгсэл багтана.

Хейдж гэдэг нь хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн, мөнгөн гүйлгээг ирээдүйд гарах өөрчлөлтөөс хамгаалж, дериватив хэрэгсэл гаргах замаар эрсдэлийг бууруулах арга юм. Бодит үнэ цэнийн хейдж, мөнгөн гүйлгээний хейдж, гадаадын цэвэр хөрөнгө оруулалтын хейдж гэсэн гурван төрлийн хейдж байдаг.

Үнэлгээ, хэмжилт

Деривативыг ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэх санхүүгийн хөрөнгө эсхүл санхүүгийн өр төлбөрөөр тайлагнана. Хэлцлийн онцлог, тоо мэдээний олдоц, зэргийг харгалзан деривативын бодит үнэ цэнийг тодорхойлно. Өөрөөр хэлбэл бодит үнэ цэн эерэг бол хөрөнгө, сөрөг бол өр төлбөр үүснэ.

Санхүүгийн тайланд толилуулах

Деривативыг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа хугацааг харгалзана. Дериватив нэг жил хүртэлх хугацаатай бол “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Бусад санхүүгийн хөрөнгө”-өөр 1.1.5 дугаар мөрөнд, нэг жилээс дээш хугацаатай бол “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Бусад эргэлтийн бус хөрөнгө”-өөр 1.2.8 дугаар мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Дахин үнэлгээний үр дүнд деривативыг үнэлгээ эерэг гарсан бол:

Дебет: Дериватив хөрөнгө

Кредит: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний олз

Дахин үнэлгээний үр дүнд деривативыг үнэлгээ сөрөг гарсан бол:

Дебет: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний гарз

Кредит: Дериватив өр төлбөр

Б.6. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТООЦОО

Хамрагдах зүйлс

Урьдчилж төлсөн тооцоонд түр хугацаагаар байршуулсан барьцаа хөрөнгө, дэнчин болон бусдаас авах бараа, ажил, үйлчилгээний үнэнд төлсөн урьдчилгаа төлбөрийг бүртгэнэ.

Үнэлгээ, хэмжилт

Урьдчилж төлсөн тооцоог өртгөөр буюу төлсөн мөнгөн дүнгээр үнэлж, толилуулна.

Данснаас хасах

Дараах тохиолдолд урьдчилж төлсөн тооцооны дансыг зарлагдаж бүртгэнэ:

- Үнэт цаасны арилжааны төлбөрийг хийснээр урьдчилгаа төлбөрийг кредитлэнэ.
- Барьцаа хөрөнгө болон дэнчинд тавьсан хөрөнгөө эргүүлэн авахад холбогдох урьдчилж төлсөн тооцооны дансыг кредитлэнэ.
- Урьдчилж төлсөн зардлыг хэрэгжсэн үед кредитлэнэ.

Санхүүгийн тайланд толилуулах

Урьдчилж төлсөн тооцоог санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Урьдчилж төлсөн зардал/тооцоо”-гоор 1.1.7 дугаар мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Үнэт цаасыг худалдан авахаар брокерын дансанд мөнгө байршуулахад:

Дебет: Урьдчилгаа төлбөр

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Үнэт цаасыг худалдан авсан үед урьдчилгаа төлбөрийн дансыг хаана:

Дебет: Үнэт цаасны холбогдох данс

Кредит: Урьдчилгаа төлбөр

Барьцаа хөрөнгө, дэнчин байршуулахад болон дараа тооцоо хийхээр урьдчилгаа төлбөр шилжүүлэхэд:

Дебет: Урьдчилж төлсөн тооцоо

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Барьцаа хөрөнгө болон дэнчинд тавьсан хөрөнгөө эргүүлэн авахад:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

Зардлыг хүлээн зөвшөөрөхдөө:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Урьдчилж төлсөн тооцоо

Б.7. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ХӨРӨНГӨ

Тодорхойлолт

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө гэж хөрөнгийн үнийн өсөлтөөс өгөөж хүртэх, түрээсийн орлого олох зорилгоор өмчилж буй үл хөдлөх хөрөнгө буюу барилга байгууламжийг хэлнэ.

Үнэлгээ, хэмжилт

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг худалдан авсан бол анхны өртөг нь хөнгөлөлт, буцаалтыг хассан худалдан авалтын үнэ, гаалийн татвар, буцаан олгогдохгүй худалдааны татвар болон тухайн хөрөнгийг бэлэн болгох нөхцлийг хангахад шууд хамаарах зардал зэргээс бүрдэнэ.

Хөрөнгийг өөрөө барьж байгуулсан бол хөрөнгийн анхны өртөг нь барилгын материал, шууд холбогдох цалин хөлс, тэтгэвэр тэтгэмж, талбай бэлтгэх зардал, бусад холбогдох нэмэлт зардал болон барилгын ажлыг гэрээгээр гүйцэтгэгчид төлөх төлбөр зэргээс бүрдэнэ. Энэ тохиолдолд хөрөнгийн өртөгт НББОУС 23-д заасан шалгуурыг хангасан хүүгийн зардлыг оруулах ба харин хэвийн бус хорогдол гэж үзэх зардлыг оруулахгүй.

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг дахин үнэлгээний загвараар бүртгэж, санхүүгийн тайланд толилуулна.

Хөрөнгийг бүртгэх дахин үнэлгээний загвар гэдэг нь хөрөнгийг хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралтыг тусгасан бодит үнэ цэнийг илтгэх дүнгээр үнэлэхийг ойлгоно. Энэ тохиолдолд тодорхой хугацааны давтамжтайгаар дахин үнэлгээг үргэлжлүүлэн хийх шаардлагатай болно. Дахин үнэлгээг хийх давтамж нь хөрөнгийн бодит үнэ цэнийн

өөрчлөлтөөс шалтгаална. Хөрөнгийн дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү үүсч байвал зайлшгүй дахин үнэлгээг хийнэ.

Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийг эрх бүхий хараат бус үнэлгээчнээр үнэлүүлнэ.

Санхүүгийн тайланд толилуулах

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө”-өөр 1.2.7 дугаар мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө худалдан авсан бол анхны өртгөөр нь:

Дебет: Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Хөрөнгөнд элэгдэл байгуулахдаа:

Дебет: Элэгдлийн зардал
Кредит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн нөхцөлд дахин үнэлгээний олз бүртгэнэ:

Дебет: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс
Кредит: Хөрөнгийн дахин үнэлгээний олз

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол бууралтыг үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз бүртгэнэ:

Дебет: Хөрөнгийн дахин үнэлгээний гарз
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс

Хэрэв хөрөнгийг алдагдалтай худалдсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс (худалдан авсан дүнгээр)
Дебет: Хөрөнгө борлуулсны гарз (зөрүүгээр)
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс (дансны үнээр)

Хэрэв хөрөнгийг ашигтай худалдсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс (худалдан авсан дүнгээр)
Кредит: Хөрөнгө борлуулсны олз (зөрүүгээр)
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс (дансны үнээр)

Б.8. БУСАД ХӨРӨНГӨ

Тодорхойлолт

Хөрөнгө оруулалтын сангийн эзэмшиж буй бусад хөрөнгийг эргэлтийн болон эргэлтийн бус гэж ангилна. Эргэлтийн хөрөнгө гэж нэг жилийн дотор эзэмшиж, эргүүлэн арилжихаар төлөвлөж буй хөрөнгийг хэлнэ. Харин эргэлтийн бус хөрөнгө нь харьцангуй хөрвөх чадвар багатай бөгөөд нэгээс дээш жилийн хугацаагаар эзэмшиж, урт хугацааны өгөөж хүртэхээр төлөвлөж буй хөрөнгийг хэлнэ.

Бусад эргэлтийн хөрөнгөнд уул уурхайн бүтээгдэхүүн болон хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөр худалдан авч, эзэмшиж буй арилжааны зориулалттай бусад хөрөнгө хамрагдана.

Бусад эргэлтийн бус хөрөнгөнд газар эзэмших эрх, төрөлжсөн хөрөнгө оруулалтын зорилгоор эзэмшиж буй бусад хөрөнгө хамрагдана.

Үнэлгээ, хэмжислт

Бусад эргэлтийн хөрөнгийг бодит үнэ цэнээр үнэлж, санхүүгийн тайланд толилуулна.

Уул уурхайн бүтээгдэхүүнд арилжаалах боломжтой буюу биржээр дамжуулан арилжаалагддаг бүтээгдэхүүнийг хэлнэ. Уул уурхайн бүтээгдэхүүнийг бодит үнэ цэнээс боловсруулалт болон худалдааны зардлыг хассан цэвэр дүнгээр үнэлж, тайлагнана. Уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдсан үед арилжааны орлого, зардал хүлээн зөвшөөрч, бүртгэнэ.

Бусад эргэлтийн бус хөрөнгийг дахин үнэлгээний загвараар бүртгэж, санхүүгийн тайланд толилуулна.

Санхүүгийн тайланд толилуулах

Бусад хөрөнгө нэг жил хүртэлх хугацаатай бол “Эргэлтийн хөрөнгө” бүлгийн “Бусад эргэлтийн хөрөнгө”-өөр 1.1.8 дугаар мөрөнд, нэг жилээс дээш хугацаатай бол “Эргэлтийн бус хөрөнгө” бүлгийн “Бусад эргэлтийн бус хөрөнгө”-өөр 1.2.8 дугаар мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Уул уурхайн бүтээгдэхүүнийг худалдан авахдаа:

Дебет: Уул уурхайн бүтээгдэхүүн
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Дахин үнэлгээний үр дүнд уул уурхайн бүтээгдэхүүний дансны үнэ нэмэгдсэн бол:

Дебет: Уул уурхайн бүтээгдэхүүн
Кредит: Хөрөнгийн дахин үнэлгээний олз

Дахин үнэлгээний үр дүнд уул уурхайн бүтээгдэхүүний дансны үнэ буурсан бол:

Дебет: Хөрөнгийн дахин үнэлгээний гарз
Кредит: Уул уурхайн бүтээгдэхүүн

Хэрэв уул уурхайн бүтээгдэхүүнийг алдагдалтай худалдсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс (худалдан авсан дүнгээр)
Дебет: Хөрөнгө борлуулсны гарз (зөрүүгээр)
Кредит: Уул уурхайн бүтээгдэхүүн (дансны үнээр)

Хэрэв уул уурхайн бүтээгдэхүүнийг ашигтай худалдсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс (худалдан авсан дүнгээр)
Кредит: Хөрөнгө борлуулсны олз (зөрүүгээр)
Кредит: Уул уурхайн бүтээгдэхүүн (дансны үнээр)

Эргэлтийн бус хөрөнгө худалдан авсан бол анхны өртгөөр нь:

Дебет: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Хөрөнгөнд элэгдэл байгуулахдаа:

Дебет: Элэгдлийн зардал
Кредит: Холбогдох хуримтлагдсан элэгдэл

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн нөхцөлд дахин үнэлгээний олз бүртгэнэ:

Дебет: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс
Кредит: Хөрөнгийн дахин үнэлгээний олз

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол бууралтыг үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз бүртгэнэ:

Дебет: Хөрөнгийн дахин үнэлгээний гарз
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс

Хэрэв эргэлтийн бус хөрөнгийг алдагдалтай худалдсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс (худалдан авсан дүнгээр)
Дебет: Хөрөнгө борлуулсны гарз (зөрүүгээр)
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс (дансны үнээр)

Хэрэв эргэлтийн бус хөрөнгийг ашигтай худалдсан бол:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс (худалдан авсан дүнгээр)
Кредит: Хөрөнгө борлуулсны олз (зөрүүгээр)
Кредит: Холбогдох эргэлтийн бус хөрөнгийн данс (дансны үнээр)

В. ӨР ТӨЛБӨР

Тодорхойлолт

Өнгөрсөн үйл ажиллагааны үр дүнд бий болсон, эдийн засгийн өгөөжийг өөртөө агуулж буй нөөцийн гадагшлах урсгалаар төлөгдөхөөр хүлээгдэж буй бөгөөд хөрөнгө оруулалтын сангийн бусдын өмнө хүлээх үүрэг хариуцлагыг өр төлбөр гэнэ.

Ангилал

Санхүүгийн тайланд өр төлбөрийг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Бусдад өгөх өглөг
- Гаргасан репо хэрэгсэл
- Татварын өглөг
- Гаргасан өрийн хэрэгсэл
- Дериватив өр төлбөр
- Хойшлогдсон татварын өглөг

Хүлээн зөвшөөрөх

Хүлээсэн үүргээ биелүүлснээр эдийн засгийн өгөөж буурах магадлалтай бөгөөд дүнг нь бодитой хэмжих боломжтой тохиолдолд өр төлбөрийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч, толилуулна.

Данснаас хасах

Өр төлбөрийг бий болгосон гэрээ, хэлцлээр хүлээсэн үүргийг бүрэн биелүүлсэн, гэрээний хугацаа дуусгавар болсон, эсхүл үүргээс чөлөөлөгдсөн нөхцөлд өр төлбөрийг данснаас хасч, бүртгэнэ.

В.1. БУСДАД ӨГӨХ ӨГЛӨГ

Тодорхойлолт

Бусдад өгөх өглөг гэж бусад этгээдэд мөнгө ба бусад санхүүгийн хөрөнгийг шилжүүлэхээр хүлээсэн гэрээний үүргийг хэлнэ. Үүнд: брокерт төлөх өглөг, ХОМК-д өгөх өглөг, кастодианд өгөх өглөг, мэргэжлийн үйлчилгээний өглөг, төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний өглөг, бүртгэлийн үйлчилгээний өглөг, үнэлгээний ажлын өглөг, хуримтлуулан тооцсон өглөг, ногдол ашгийн өглөг, хүүгийн өглөг багтана.

Хуримтлуулж тооцоолсон өглөг гэдэг нь төлөгдөөгүй боловч үүсч бий болсон өр төлбөрийг хэлнэ. Өөрөөр хэлбэл зардлыг хүлээн зөвшөөрч хуримтлуулах үед төлөх хэмжээгээр бүртгэсэн өр төлбөрийг энэ дансанд бүртгэнэ.

Үнэлгээ, хэмжислт

Бусдад өгөх өглөгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна.

Санхүүгийн тайланд толилуулах

Бусдад өгөх өглөгийг санхүүгийн байдлын тайланд “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Дансны өглөг”-өөр 2.1.1.1 дүгээр мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Зардлыг хүлээн зөвшөөрч, хуримтлуулан бүртгэхэд:

Дебет: Холбогдох зардлын данс

Кредит: Бусдад өгөх өглөг

Өглөгийг төлж барагдуулахад:

Дебет: Бусдад өгөх өглөг

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

В.2. ГАРГАСАН РЕПО ХЭРЭГСЭЛ

Тодорхойлолт

Хөрөнгө оруулалтын сан өөрийн эзэмшиж буй үнэт цаасыг тодорхой хугацааны эцэст урьдчилан тохиролцсон үнээр буцаан худалдан авах нөхцөлтэйгөөр худалдах хэлцлийг “гаргасан репо хэрэгсэл” гэнэ.

Хөрөнгө оруулалтын сан нь репо хэрэгсэл гаргасан бол уг хэлцлээр эргүүлэн худалдаж авах нөхцөлтэй үнэт цаасыг барьцаалан эх үүсвэр татаж байгаа тул уг үнэт цаасны ангиллыг өөрчилж, санхүүгийн тайланд “Барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө”-өөр тайлагнана. Мөн үүний зэрэгцээ тэнцлийн уг үнэт цаасыг тэнцлийн гадуурх “Барьцаа хөрөнгө”-ийн дансад бүртгэнэ.

Үнэлгээ, хэмжислт

Гаргасан репо хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр үнэлж, бүртгэх ба санхүүгийн тайланд хорогдуулсан өртгөөр үнэлж, толилуулна.

Хэрэв гэрээт хугацаандаа үнэт цаасаа эргүүлэн аваагүй, түүнд бодогдсон хүүг төлөөгүйн улмаас барьцааны үнэт цаасыг худалдан авсан талд шилжүүлсэн бол репо хэрэгслийн дансны үнэ ба барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгийн дансны үнийн зөрүүгээр олз, гарз хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн тайланд толилуулах

Гаргасан репо хэрэгслийг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа хугацааг харгалзах ба нэг жил хүртэлх хугацаатай бол “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Бусад богино хугацаат өр төлбөр”-өөр 2.1.1.10 дугаар мөрөнд, нэг жилээс дээш хугацаатай бол “Урт хугацаат өр төлбөр” бүлгийн “Бусад урт хугацаат өр төлбөр”-өөр 2.1.2.4 дүгээр мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Репо хэрэгсэл гаргахад:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Гаргасан репо хэрэгсэл

Барьцаанд тавьсан үнэт цаасны ангиллыг өөрчлөхдөө:

Дебет: Барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө

Кредит: Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн хөрөнгө
Гаргасан репо хэрэгслийн хүүг хуримтлуулан тооцоолж, бүртгэхэд:

Дебет: Хүүгийн зардал

Кредит: Холбогдох хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Хуримтлуулсан хүүг төлөхөд:

Дебет: Холбогдох хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Худалдсан үнэт цаасыг эргүүлэн худалдаж авах буюу өр төлбөрөө барагдуулахад:

Дебет: Гаргасан репо хэрэгсэл

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Хэрэв барьцааны үнэт цаасыг худалдан авсан талд шилжүүлсэн бол:

Дебет: Гаргасан репо хэрэгсэл

Кредит: Холбогдох хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Кредит: Барьцаанд тавьсан санхүүгийн хөрөнгө

В.3. ГАРГАСАН ӨРИЙН ХЭРЭГСЭЛ

Тодорхойлолт

Хөрөнгө оруулалтын сан өрийн хэрэгсэл гарган эх үүсвэр татан төвлөрүүлсэн бол гаргасан өрийн хэрэгслийг бодит үнэ цэнээр илэрхийлсэн санхүүгийн өр төлбөр гэж үзнэ. Үүнд сангийн гаргасан өрийн бичиг, вексель, бонд, дериватив хэрэгсэл, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас зэргийг хамруулна.

Үнэлгээ, хэмжилт

Гаргасан өрийн хэрэгслийг ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр үнэлж, толилуулах ба бодит үнэлгээнд гарсан аливаа өөрчлөлтийг тайлант хугацааны орлого, зардалд хүлээн зөвшөөрнө.

Урт хугацаат санхүүгийн хэрэгслийн хүүгийн орлогыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолж, хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн өр төлбөрийг эргэн дуудаж, төлж барагдуулах үед бүртгэлд тусгасан үнэ ба худалдан борлуулсан үнийн зөрүүгээр арилжааны буюу хэрэгжсэн олз, гарз хүлээн зөвшөөрнө. Үүний зэрэгцээ өмнө нь бүртгэсэн санхүүгийн хэрэгслийн үнэлгээний хэрэгжээгүй олз, гарзыг хэрэгжсэн олз, гарз буюу арилжааны олз, гарз болгон тохируулна.

Санхүүгийн тайланд толилуулах

Гаргасан өрийн хэрэгслийг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа хугацааг харгалзах ба нэг жил хүртэлх хугацаатай бол “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Бусад богино хугацаат өр төлбөр”-өөр 2.1.1.10 дугаар мөрөнд, нэг жилээс дээш хугацаатай бол “Урт хугацаат өр төлбөр” бүлгийн “Бусад урт хугацаат өр төлбөр”-өөр 2.1.2.4 дүгээр мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Санхүүгийн хэрэгслийг гаргасан өдөр татан төвлөрүүлсэн хөрөнгө буюу бодит үнэ цэнээр нь үнэлж, бүртгэхэд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Кредит: Гаргасан өрийн хэрэгсэл

Өрийн хэрэгсэлд төлөх хүүг хуримтлуулан тооцоолж, бүртгэхэд:

Дебет: Хүүгийн зардал

Кредит: Холбогдох хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Хүүг төлөхөд:

Дебет: Холбогдох хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Санхүүгийн хэрэгслийг дахин үнэлж, бодит үнэ цэнээр илэрхийлэх үед бодит үнэ цэн нь бүртгэсэн үнээс бага байвал бууруулах дүнгээр:

Дебет: Санхүүгийн өр төлбөрийн холбогдох данс

Кредит: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний олз

Санхүүгийн хэрэгслийг дахин үнэлж, бодит үнэ цэнээр илэрхийлэх үед бодит үнэ цэн нь бүртгэсэн үнээс илүү байвал өсгөх дүнгээр:

Дебет: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний гарз

Кредит: Санхүүгийн өр төлбөрийн холбогдох данс

Санхүүгийн өр төлбөрийг эргэн дуудан, төлж барагдуулах үед санхүүгийн хэрэгслийг бүртгэлд тусгасан үнээр эргэн дуудсан бол ямар нэгэн олз, гарз үүсэхгүй:

Дебет: Санхүүгийн өр төлбөрийн холбогдох данс

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Санхүүгийн өр төлбөрийг эргэн дуудан, төлж барагдуулах үед санхүүгийн хэрэгслийг бүртгэлд тусгасан үнээс дээгүүр үнээр эргэн дуудсан бол эдгээрийн зөрүүгээр гарз хүлээн зөвшөөрнө:

Дебет: Санхүүгийн өр төлбөрийн холбогдох данс

Дебет: Санхүүгийн хэрэгслийн арилжааны гарз

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Санхүүгийн өр төлбөрийг эргэн дуудан, төлж барагдуулах үед санхүүгийн хэрэгслийг бүртгэлд тусгасан үнээс доогуур үнээр эргэн дуудсан бол эдгээрийн зөрүүгээр олз хүлээн зөвшөөрнө:

Дебет: Санхүүгийн өр төлбөрийн холбогдох данс

Кредит: Санхүүгийн хэрэгслийн арилжааны олз

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Үүний зэрэгцээ өмнө нь бүртгэсэн санхүүгийн хэрэгслийн үнэлгээний хэрэгжээгүй олз, гарзыг хэрэгжсэн олз, гарз буюу арилжааны олз, гарз болгон тохируулна.

Дахин үнэлгээний үр дүнд цэвэр гарзыг тодорхойлж бүртгэсэн санхүүгийн хэрэгслийн хувьд:

Дебет: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний гарз

Кредит: Санхүүгийн хэрэгслийн арилжааны олз

эсхүл

Дахин үнэлгээний үр дүнд цэвэр олзыг тодорхойлж бүртгэсэн санхүүгийн хэрэгслийн хувьд:

Дебет: Санхүүгийн хэрэгслийн арилжааны гарз

Кредит: Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний гарз

В.4. ӨР ТӨЛБӨРТ БҮРТГЭСЭН НЭГЖ ЭРХ

Тодорхойлолт

Нэгж эрх эзэмшигчдэд мөнгө болон бусад санхүүгийн хөрөнгө шилжүүлэх гэрээний бус үүрэг үүссэн нөхцөлд нэгж эрхийг өр төлбөрөөр ангилж, “Өр төлбөрт бүртгэсэн нэгж эрх” дансанд бүртгэн, тайлагнана.

Үнэлгээ, хэмжилт

Нэгж эрхийг барагдуулахаар өр төлбөрт шилжүүлэн бүртгэсэн өдрийн цэвэр хөрөнгийн үнэлгээгээр өр төлбөрийг хэмжиж, үнэлнэ.

Санхүүгийн тайланд толилуулах

Өр төлбөрт бүртгэсэн нэгж эрхийг санхүүгийн байдлын тайланд толилуулахдаа түүнийг эргүүлэн авах хугацааг харгалзана. Нэг жил хүртэлх хугацаанд нэгж эрхийг эргүүлэн худалдаж авах бол “Богино хугацаат өр төлбөр” бүлгийн “Бусад богино хугацаат өр төлбөр”-өөр 2.1.1.10 дугаар мөрөнд, нэг жилээс дээш хугацаатай бол “Урт хугацаат өр төлбөр” бүлгийн “Бусад урт хугацаат өр төлбөр”-өөр 2.1.2.4 дүгээр мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Нэгж эрхийг өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч, ангиллыг өөрчлөн шилжүүлж бичихдээ:

Дебет: Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө
Кредит: Өр төлбөрт бүртгэсэн нэгж эрх

Өр төлбөрт шилжүүлсэн нэгж эрхийн төлбөрийг барагдуулахад:

Дебет: Өр төлбөрт бүртгэсэн нэгж эрх
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Г. ЦЭВЭР ХӨРӨНГӨ

Тодорхойлолт

Эздийн өмч буюу цэвэр хөрөнгө нь сангийн бүх өр төлбөрийг барагдуулсны дараа үлдэх хөрөнгө юм.

Ангилал

Санхүүгийн байдлын тайланд эздийн өмчийг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө
- Хуримтлагдсан ашиг (алдагдал)

Хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэгж эрхээ худалдах болон эргүүлэн худалдан авах ажиллагааг зохицуулсан журамтай байх бөгөөд түүнд сангийн хөрөнгийн төвлөрлийн хязгаарлалтыг тусгасан байна.

Сангийн цэвэр хөрөнгийн тооцоолол

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгийн дүн гэж хөрөнгө оруулалтын сангийн багцад байгаа нийт хөрөнгийн бодит үнэ цэнээс нийт өр төлбөрийн бодит үнэ цэнийг хассан цэвэр дүнг хэлнэ.

$$\text{Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө} = \text{Нийт хөрөнгийн бодит үнэ цэн} - \text{Нийт өр төлбөрийн бодит үнэ цэн}$$

Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн үнэ нь нэгж эрхийн нэгжид ногдох цэвэр хөрөнгийн үнэлгээг харуулах ба үүнийг тооцоолохдоо сангийн цэвэр хөрөнгийн дүнг гаргасан нэгж эрхийн тоонд хуваана.

$$\text{Нэгж эрхийн үнэ} = \frac{\text{Цэвэр хөрөнгийн дүн}}{\text{Гаргасан нэгж эрхийн тоо}}$$

Гаргасан нэгж эрхийн тоог тодорхойлохдоо дараах аргачлалыг мөрдөнө:

$$\text{Гаргасан нэгж эрхийн тоо} = \text{Хугацааны эхэнд гаргасан байсан нэгж эрхийн тоо} + \text{Тайлант хугацаанд нэмж гаргасан нэгж эрхийн тоо} - \text{Тайлант хугацаанд эргүүлэн худалдан авсан нэгж эрхийн тоо}$$

ХОМК-д ногдох цэвэр хөрөнгө нь ХОМК-ийн эзэмшиж буй нэгж эрхийн нийт үнэлгээг хэлнэ.

$$\text{ХОМК-д ногдох цэвэр хөрөнгө} = \text{ХОМК-ийн эзэмшиж буй нэгж эрхийн тоо} * \text{Нэгж эрхийн үнэ}$$

ХОМК-ийн эзэмшиж буй нэгж эрхийн тоог ХОМК-иас сангийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд заавал оруулах хөрөнгийн дүн дээр сангийн нийт хөрөнгөөс тодорхой хувиар тооцож нэмсэн дүнд үндэслэн тооцно.

Нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгө нь ХОМК-аас бусад нэгж эзэмшигчдийн эзэмшиж буй нэгж эрхийн нийт үнэлгээг хэлнэ.

$$\text{Нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгө} = \text{Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө} - \text{ХОМК-д ногдох цэвэр хөрөнгө}$$

Нөгөө талаас энэ үзүүлэлтийг нэгж эрхийн үнийг нэгж эрх эзэмшигчдийн эзэмшиж буй нэгж эрхийн тоогоор үржүүлэн тооцоолж болох бөгөөд энэ хоёр аргачлалаар хийсэн тооцоо ижил үр дүнд хүргэнэ.

Цэвэр хөрөнгийн жилийн жинэлсэн дундаж үлдэгдлийг дараах байдлаар тооцоолно. Үүнд:

$$\text{Цэвэр хөрөнгийн жинэлсэн дундаж үлдэгдэл} = \text{Тодорхой хугацаагаар тасалбар болгосон цэвэр хөрөнгийн дүн} * \text{Жилийн туршид цэвэр хөрөнгийн дүнг үнэлэх давтамж}$$

Нэгж эрхээ өдөр бүр гаргаж, эргүүлэн худалдаж авах үүрэг хүлээсэн нээлттэй сангийн хувьд цэвэр хөрөнгийн дүнг өдөр бүр, долоо хоног бүр нэгж эрхээ эргүүлэн худалдан авдаг сангийн хувьд долоо хоног бүр, сар бүр нэгж эрхээ эргүүлэн авдаг сангийн хувьд сар бүр цэвэр хөрөнгийн дүнг тодорхойлно.

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгийн дүнг бодитой тооцоолохын тулд хөрөнгө оруулалтын сангийн төлөх ёстой үйлчилгээний хөлсийг өдөрт ногдуулан тооцоолж, бүртгэлд тусгана.

Санхүүгийн тайланд толилуулах

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгийн дүнг санхүүгийн байдлын тайланд “Эздийн өмч” бүлгийн “Өмч”-өөр харгалзах 2.3.1, 2.3.2 эсхүл 2.3.3 дугаар мөрөнд толилуулна.

Хуримтлагдсан ашиг, алдагдлыг санхүүгийн байдлын тайланд “Эздийн өмч” бүлгийн “Хуримтлагдсан ашиг”-аар 2.3.9 дүгээр мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах үед ХОМК-иас анхны хөрөнгө оруулалт хийсэн бол оруулсан хөрөнгийн дүнгээр сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлнэ:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө

Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгыг нийтэд санал болгож, нэгж эрхээ гаргах замаар хөрөнгө татан төвлөрүүлэн бол төвлөрүүлсэн хөрөнгийн дүнгээр сангийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлнэ:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө

Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн цэвэр хөрөнгийн дүнг тооцоолж, тайлант хугацааны ашгийг нэгж эрх эзэмшигчдэд хуваарилсан бол:

Дебет: Хуваарилагдаагүй ашиг (алдагдал)
Кредит: Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө

Нэгж эрх эзэмшигчээс нэгж эрхийг эргүүлэн худалдан авсан буюу нэгж эрх эзэмшигч хөрөнгөө татан авсан бол:

Дебет: Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө
Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Д. ОРЛОГО

Тодорхойлолт

Орлого нь тайланд хугацаанд хөрөнгийн дотогшлох урсгал болон хөрөнгийн сайжруулалт, эсхүл нэгж эрх эзэмшигчдээс оруулсан хөрөнгөтэй холбоогүйгээр өөрийн хөрөнгийг нэмэгдүүлж, өр төлбөрийг бууруулах хэлбэрээр гарах эдийн засгийн үр өгөөжийн өсөлт юм.

Олз, гарз гэж сангийн үйл ажиллагааны явцад үүссэн, бодит ба бодит бус боловч орлого, зардлын тодорхойлолтонд нийцэх бусад зүйлсийг ойлгоно. Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарз, санхүүгийн хэрэгслийн үнэлгээний ба арилжааны олз, гарз зэргийг тусад нь бүртгэж, санхүүгийн тайланд толилуулна. Эдгээрээс бусад олз, гарзыг бусад орлого, зардалд тайлагнана.

Ангилал

Санхүүгийн тайланд орлогыг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Хөрөнгө оруулалтын орлого
- Бусад орлого

Хөрөнгө оруулалтын орлогод сангийн худалдан авч эзэмшиж буй санхүүгийн хэрэгслийн хүү, ногдол ашгийн орлого хамрагдана.

Хүлээн зөвшөөрөх

Орлогын дүнг бодитой тооцон гаргах боломжтой бөгөөд ажил гүйлгээний эцсийн өгөөжийг хүртэх магадлалтай нөхцөлд орлогыг хүлээн зөвшөөрнө.

Үнэлгээ, хэмжилт

Орлогыг хүлээн авсан мөнгө эсхүл үүссэн авлагын бодит үнэ цэнээр үнэлнэ.

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монголбанкнаас зарласан албан ханшаар хөрвүүлэх үед үүссэн зөрүүг ханшийн зөрүүгийн олз, гарзад бүртгэнэ. Мөн энэ дансанд гадаад валютаар хийгдсэн ажил гүйлгээний явцад үүссэн ханшийн зөрүүг бүртгэнэ.

Сан нь санхүүгийн хэрэгслийг бодит үнэ цэнээр үнэлж, тайлагнахтай холбогдуулан үүссэн үнэлгээний өсөлт, бууралтыг санхүүгийн хэрэгслийн үнэлгээний олз, гарзад бүртгэж, толилуулна. Харин санхүүгийн хэрэгслийг худалдах эсхүл эргэн дуудах үед үүссэн зөрүүг арилжааны олз, гарзад бүртгэж, тайлагнана.

Санхүүгийн тайланд толилуулах

Орлогын дэлгэрэнгүй тайланд хүүгийн орлогыг 5 дугаар мөрөнд, ногдол ашгийн орлогыг 6 дугаар мөрөнд, түрээсийн орлогыг 4 дүгээр мөрөнд, бусад орлогыг 8 дугаар мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Хүүгийн орлого хүлээн зөвшөөрч, бүртгэхэд:

Дебет: Хүүгийн авлага
Кредит: Хүүгийн орлого

Эзэмшиж буй өмчийн үнэт цаасанд ногдол ашиг зарлахад:

Дебет: Ногдол ашгийн авлага
Кредит: Ногдол ашгийн орлого

Хөрөнгийн түрээсийн орлогыг хүлээн авч, бүртгэхэд:

Дебет: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс
Кредит: Түрээсийн орлого

Е. ЗАРДАЛ

Тодорхойлолт

Зардал нь нэгж эрх эзэмшигчдэд олгосон хуваарилалттай холбоогүй, цэвэр хөрөнгийг бууруулж буй хөрөнгийн хорогдол буюу гадагшлах урсгал эсхүл өр төлбөр үүсэх зэрэг хэлбэрээр тайлант хугацаанд бий болсон эдийн засгийн өгөөжийн бууралт юм.

Ангилал

Санхүүгийн тайланд зардлыг дараах байдлаар ангилж, толилуулна.

- Ерөнхий удирдлагын зардал
- Санхүүгийн зардал
- Бусад зардал
- Орлогын албан татварын зардал

Хүлээн зөвшөөрөх

Зардлын дүнг бодитой тооцох боломжтой бөгөөд ажил гүйлгээний үр дүнд эдийн засгийн өгөөж буурсан нөхцөлд зардлыг хүлээн зөвшөөрнө.

Үнэлгээ, хэмжилт

Зардлыг төлсөн мөнгө эсхүл үүссэн өглөгийн бодит үнэ цэнээр үнэлнэ.

Хөрөнгө оруулалтын сангийн төлөх үйлчилгээний хөлсийг өдөрт ногдуулан тооцоолж, бүртгэлд тусгахдаа дараах аргачлалаар хүлээн зөвшөөрөх зардлын дүнг тооцоолно. Үүнд:

$$\text{Үйлчилгээний зардлын дүн} = \frac{\text{Сангийн нийт хөрөнгийн дундаж үлдэгдэл}}{\text{Жилийн зардлын дундаж хувь}} \times \frac{\text{Тооцоолж буй өдрийн тоо}}{365^1}$$

Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах бичиг баримт, ХОМК-тай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд заасан нөхцөлд ХОМК-д гүйцэтгэлийн урамшуулал олгож болно. Гүйцэтгэлийн урамшууллыг нэгж эрхийн үнэ нь нэгж эрхийн нэрлэсэн үнээс илүү байсан нөхцөлд олгоно.

Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгийн өгөөж нь санг үүсгэн байгуулах баримт бичигт тогтоосон хувиас илүү өндөр түвшинд хүрсэн тохиолдолд энэхүү тогтоосон хувиас илүү гарсан хувиас гүйцэтгэлийн урамшууллын дүнг тооцно.

Хөрөнгө оруулалтын сангийн үүсгэн байгуулах бичиг баримтаар зөвшөөрсөн бөгөөд сангийн танилцуулгад тусгасан бол нэгж эрхийн арилжаанд шимтгэл ногдуулах замаар хөрөнгө оруулагчдаас урьдчилан тооцож авсан шимтгэлийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын сангийн

¹ Хэрвээ нэгж эрхээ 7 хоногт нэг удаа эргүүлэн худалдан авахаар тогтоосон бол өдрийн тоог 7 гэж авна, сар бүр эргүүлэн авдаг бол өдрийн тоог 30 гэж авна. 2- Хэрвээ нэгж эрхээ өдөр бүр эргүүлэн авахаар дүрэмдээ заасан бол жилд 365 удаа, сар бүр бол 12 удаа, 7 хоног бүр бол 52 удаа байна. Жишээ нь: Сард нэг удаа нэгж эрхээ эргүүлэн худалдан авдаг бол сарын бүрийн эцэст байгаа цэвэр активын үлдэгдлийг 12-т хуваагаад нийлбэрийг нь гаргах замаар цэвэр активын жилийн дундаж үлдэгдлийг тооцоолно.

үйл ажиллагааг явуулахтай холбоотой эсхүл нэгж эрхийг гаргах, эргүүлэн авахтай холбоотой зардлыг нөхөж болно.

Хэрэв сан арилжаанаас шимтгэл авах замаар зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлээгүй бол сангийн хөрөнгөөр зардлыг санхүүжүүлнэ.

Хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгөөс зардлыг санхүүжүүлэхээр сангийн үүсгэн байгуулах бичиг баримт болон танилцуулгад заасан бол эдгээр бичиг баримтад сангаас төлөх төлбөр хураамж зэрэг зардлын дээд хязгаарыг тогтоосон байна.

Эдгээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн жилийн дундаж үлдэгдлийн 1% эсхүл нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгийн дүнгийн 1%-иас хэтрэхгүй байна.

Сангийн үйл ажиллагаатай холбогдон гарах зардлын дээд хязгаарыг сангийн танилцуулга болон ХОМК-тай байгуулах хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээнд тусгасан байна.

Санхүүгийн тайланд толилуулах

Ерөнхий удирдлагын зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд 10 дугаар мөрөнд, санхүүгийн зардлыг 11 дүгээр мөрөнд, бусад зардлыг 12 дугаар мөрөнд, орлогын албан татварын зардлыг 19 дүгээр мөрөнд толилуулна.

Нягтлан бодох бүртгэл хөтлөлт

Санхүүгийн зуучлалтай холбоотой төлсөн шимтгэлийг ажил гүйлгээний зардалд бүртгэнэ:

Дебет: Ажил гүйлгээний зардал

Кредит: Брокерт төлөх өр

Брокерт төлөх өрийг барагдуулсан үед:

Дебет: Брокерт төлөх өр

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх эзэмшигчдэд зарласан ногдол ашгийг хуримтлуулан тооцоолж, бүртгэхэд:

Дебет: Ногдол ашгийн зардал

Кредит: Ногдол ашгийн өглөг

Ногдол ашгийг төлөхөд:

Дебет: Ногдол ашгийн өглөг

Кредит: Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн данс

ХОМК-д төлөх үйлчилгээний хөлсийг өдөрт ногдуулан тооцоолж, хуримтлуулан бүртгэхдээ:

Дебет: ХОМК-ийн үйлчилгээний зардал

Кредит: ХОМК-д өгөх өглөг

Тайлант хугацааны эцэст хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагааны санхүүгийн үр дүнг харгалзан үзэж, ХОМК-д гүйцэтгэлийн урамшуулал олгохоор болсон бол тооцоолсон дүнгээр өглөг хүлээн зөвшөөрнө:

Дебет: Гүйцэтгэлийн урамшуулал

Кредит: ХОМК-д өгөх өглөг

Ё. ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСД

Тодорхойлолт

Тэнцлийн гадуурх дансд нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангаагүй боловч дэлгэрүүлж бүртгэн, тодруулах шаардлагатай зүйлсийг бүртгэх дансд юм.

Ангилал

Тэнцлийн гадуурх дансдыг дараах байдлаар ангилж, толилуулна. Үүнд:

- Хүлээсэн болзошгүй үүрэг
- Барьцаа хөрөнгө
- Дериватив санхүүгийн хэрэгсэл
- Барьцаанд тавьсан хөрөнгө
- Бусад дансд

Хүлээсэн болзошгүй үүрэг

Хүлээсэн болзошгүй үүргийн дансанд гэрээ, хэлцлийн үндсэн дээр бусдын өмнө хөрөнгө оруулалтын сангийн хүлээсэн үүргийг бүртгэнэ.

Хөрөнгө оруулалтын сан үүрэг хүлээсэн бол хүлээсэн үүргийн нийт дүнгээр “Хүлээсэн болзошгүй үүрэг”-ийн дансанд орлогодоно. Хүлээсэн үүргээ биелүүлсэн, үүргээ чөлөөлөгдсөн, үүрэг хүлээсэн хугацаа дуусгавар болсон, үүргийг цуцалсан зэрэг шалтгаанаар хүлээсэн үүрэг дуусгавар болоход энэ данснаас зарлагадана.

Барьцаа хөрөнгө

Барьцаа хөрөнгийн дансанд санхүүгийн хэрэгсэл, арилжааны гэрээ, хэлцлийн барьцаанд авсан хөрөнгийг бүртгэнэ. Тухайлбал, урвуу репо хэрэгсэл авахад уг хэлцлийн барьцаанд буй эргүүлэн худалдах үнэт цаас нь барьцаа хөрөнгө болно.

Барьцаа хөрөнгийг хөрөнгийн төрлөөр ангилж, нэрлэсэн дүн болон тоо ширхэгээр бүртгэнэ.

Хөрөнгийг эргүүлэн өгөх нөхцөлтэйгөөр барьцаанд авахад “Барьцаа хөрөнгө”-ийн дансанд орлогодох ба хөрөнгийг эргүүлэн өгөхөд энэ данснаас зарлагадана.

Дериватив санхүүгийн хэрэгсэл

Дериватив санхүүгийн хэрэгсэлийн дансанд бусадтай хийсэн дериватив хэлцлийн үр дүнд үүссэн авлага, өглөгийг нийт дүнгээр бүртгэнэ.

Хэлцэл хийсэн өдрөөр холбогдох авлага, өглөгийн дансдыг орлогодох ба хэлцэл дуусгавар болсноор зарлагадана.

Барьцаанд тавьсан хөрөнгө

Барьцаанд тавьсан хөрөнгө дансанд гэрээ, хэлцлийн дагуу барьцаанд тавьсан хөрөнгийг бүртгэнэ.

Барьцаанд тавьсан хөрөнгийг хөрөнгийн төрлөөр ангилж, нэрлэсэн дүн болон тоо ширхэгээр бүртгэнэ.

Хөрөнгийг барьцаанд тавьж, бусдад өгөхөд “Барьцаанд тавьсан хөрөнгө”-ийн дансанд орлогодох ба хөрөнгийг эргүүлэн авахад энэ данснаас зарлагадана.

Бусад дансд

Тэнцлийн гадуурх бусад дансдад эзэмшиж буй үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө болон бусад хөрөнгийг нэр төрлөөр нь ангилж, тоо ширхэг, нэрлэсэн дүнгээр нь бүртгэнэ.

Дээрх хөрөнгийг хүлээн зөвшөөрч санхүүгийн тайланд толилуулахад тэнцлийн гадуурх дансыг орлогодох ба данснаас хасахад тэнцлийн гадуурх данснаас зарлагадана.

Санхүүгийн тайланд толилуулах

Тэнцлийн гадуурх дансдын талаарх мэдээллийг санхүүгийн тайлангийн тодруулгын “Бусад эргэлтийн бус хөрөнгө”, “Өр төлбөр”, “Болзошгүй хөрөнгө ба өр төлбөр” зэрэг холбогдох хэсэгт тайлбарлаж тодруулна.

Ж. ХӨРӨНГӨ, ӨР ТӨЛБӨРИЙН БОДИТ ҮНЭ ЦЭНИЙГ ТОДОРХОЙЛОХ

Хөрөнгө оруулалтын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх бүрт хөрөнгө, өр төлбөрийг бодит үнэ цэнээр илэрхийлж, толилуулна.

Хөрөнгө оруулалтын сангийн цэвэр хөрөнгийн дүн буюу хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг үнэлэх давтамжийг Хорооноос баталсан холбогдох журмаар зохицуулна.

Хамтын хөрөнгө оруулалтын сан нь нэгж эрхээ худалдах болон эргүүлэн худалдан авах ажиллагааг зохицуулсан журамтай байх бөгөөд түүнд сангийн хөрөнгийн төвлөрлийн хязгаарлалтыг тусгасан байна.

Хувийн хөрөнгө оруулалтын сангийн багцад багтаж буй үл хөдлөх хөрөнгө болон эрхийн бодит үнэ цэнийг эрх бүхий хараат бус үнэлгээчнээр үнэлүүлнэ.

Бодит үнэ цэн гэж ажил гүйлгээг бүртгэх өдөр зах зээлийн оролцогчдын хооронд байнга хийгдэх арилжаагаар хөрөнгийг худалдан авах буюу өр төлбөрт шилжүүлэх үнэ юм.

Бодит үнэ цэнийг хэмжихийн тулд доор дурдсан зүйлсийг тодорхойлно. Үүнд:

- Үнэлэх гэж буй хөрөнгө өр төлбөрийг тодорхойлох.
- Санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн хувьд тэдгээрийг бодитой үнэлэх боломжтой гэсэн таамаглал буюу хамгийн сайн ашиглалтанд үндэслэн үнэлэх. Зах зээлийн оролцогчид санхүүгийн бус хөрөнгийг ашиглах хугацаанд хөрөнгө, өр төлбөрийн үнэ цэнийг дээд түвшинд байлгахыг хамгийн сайн ашиглалт гэнэ.
- Хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээл эсхүл хамгийн сайн зах зээлийг тодорхойлох. Хөрөнгө, өр төлбөрийг хамгийн өндөр дүнгээр болон хамгийн олон арилжаалсан зах зээлийг үндсэн зах зээл гэнэ. Хөрөнгийг худалдахад хамгийн өндөр үнэ хүргэж болох, өрийг барагдуулахад хамгийн бага үнэ төлж болох зах зээлийг хамгийн сайн зах зээл гэнэ.
- Мэдээллийн онцлогийг харгалзан хамгийн тохиромжтой үнэлгээний арга хандлагыг сонгож ашиглах ба мэдээлэл аль түвшний эх суралжид хамаарахыг тодорхойлох.

Хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Хөрөнгө, өр төлбөрийн төлөв байдал, байршил, түүний ашиглалт болон арилжаанд тавигдсан хязгаарлалт зэргийг харгалзан хөрөнгө, өр төлбөрийн онцлогийг тусгасан үнэлгээ хийнэ.
- Бодит үнэ цэнийг тодорхойлохдоо зах зээлийн өнөөгийн нөхцөлд хөрөнгө, өр төлбөрийг үнэлж буй өдөр зах зээлийн оролцогчдын хооронд ердийн арилжаа хийгдэнэ гэсэн таамаглал дэвшүүлнэ.
- Хөрөнгө, өр төлбөрийн үндсэн зах зээл дээр эсхүл хамгийн сайн зах зээл дээр хөрөнгийг арилжаална гэж таамагласны үндсэн дээр бодит үнэ цэнийг тодорхойлно.
- Санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрийн хувьд хамгийн сайн ашиглалтыг харгалзан үзнэ.
- Санхүүгийн болон санхүүгийн бус өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо үнэлгээ хийж буй өдөр өр төлбөрийг барагдуулах хүлээлт хэвээр байгаа бөгөөд хүчингүйд тооцох болон хойшлуулах ямар нэг нөхцөл байхгүй гэж таамаглана.
- Өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо зээлийн эрсдэлийг хамарсан гүйцэтгэлийн бус эрсдэлийн үр нөлөөг тусгана.

- Хөрөнгө, өр төлбөрийг нэгтгэж, цэвэр дүнгээр толилуулах боломжтой нөхцөлд зах зээлийн болон харилцагч талын зээлийн эрсдэлийг харгалзахгүй байж болно (энэ тухайд нэмэлт тодруулга хийнэ).

Бодит үнэ цэнийг тодорхойлоход ашиглагдах мэдээллийн эх сурвалж гурван түвшинд хуваагдана. Үүнд:

- Нэгдүгээр түвшний мэдээлэл нь хөрөнгө, өр төлбөрийн идэвхитэй зах зээлийн залруулаагүй үнэ юм. Хөрөнгө, өр төлбөрийн арилжааны давтамж, хэмжээний хувьд хүрэлцээтэй бөгөөд үндэслэлтэй мэдээллээр тогтмол хангах зах зээлийг идэвхтэй зах зээл гэнэ.
- Хоёрдугаар түвшний мэдээлэл нь хөрөнгө, өр төлбөртэй холбоотойгоор шууд болон шууд бусаар олж авах боломжтой бөгөөд нэгдүгээр түвшний мэдээллээс бусад мэдээлэл юм. Үүнд дараах мэдээлэл багтана:
 - Ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхтэй зах зээлийн үнэ
 - Яг ижил эсхүл ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн идэвхитэй бус зах зээлийн жишиг үнэ
 - Хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн үнэ ханшийн бус мэдээлэл, тухайлбал:
 - Хүүгийн түвшин, өгөөжийн муруй
 - Таамаглаж буй түвшин
 - Өрийн хэрэгсэлийн хүүгийн зөрүүний түвшин
 - Зах зээлийн нийтлэг мэдээллээс гарган авсан эсхүл тэдгээр мэдээллийг ашиглан корреляц болон бусад аргаар тооцоолж гаргасан мэдээлэл
- Гуравдугаар түвшний мэдээлэл нь хөрөнгө, өр төлбөртэй холбоотойгоор шууд олдохгүй мэдээлэл юм. Өөрөөр хэлбэл илэрхий бус, ихээхэн залруулга, тохируулга хийх шаардлагатай мэдээллийн эх сурвалжийг гуравдугаар түвшинд хамруулна.

Хэрэв хөрөнгө, өр төлбөрийг идэвхтэй зах зээлд арилжаалдаг бол идэвхтэй зах зээлийн мэдээлэл буюу нэгдүгээр түвшний мэдээллийг ашиглан хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлно.

Хөрөнгө, өр төлбөрийг идэвхитэй зах зээлд арилжаалдаггүй бол тэдгээрийн бодит үнэ цэнийг үнэлгээний арга техник ашиглан тодорхойлно. Хоёрдугаар болон гуравдугаар түвшний мэдээлэл ашиглан бодит үнэ цэнийг тооцоолохдоо үнэлгээний аргыг ашигладаг.

Хөрөнгө, өр төлбөрийг арилжаалдаг зах зээл идэвхгүй эсхүл маш хязгаарлагдмал зах зээл байгаа үед гуравдугаар түвшний мэдээллийг ашиглан тухайн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлно.

Дараах нөхцөлд хөрөнгө, өр төлбөрийн зах зээл идэвхгүй байна гэж үзнэ. Үүнд:

- Зах зээлийн арилжааны хэмжээ болон арилжааны идэвх ихээхэн буурсан
- Ханшийн мэдээллийн олдоц тодорхой цаг хугацаа болон зах зээлийн оролцогчдоос хамааран өөрчлөгддөг
- Олдож байгаа мэдээлэл нь цаг хугацааны хувьд хуучирсан
- Холбоотой талуудын хороонд их хэмжээний хэлцэл хийгддэг
- Арилжааг ямар нэг хэмжээгээр хязгаарласан
- Зах зээлийн ханш нь ямар нэг шалтгааны улмаас бодит үнэ цэнийг илэрхийлж чадахгүй байгаа. Тухайлбал: арилжаа хаагдсаны дараа үнэлгээ хийх үед томоохон

үйл явдал тохиосон бол бодит үнэ цэнийг тогтоохын тулд арилжааны ханшид залруулга хийх шаардлагатай болно.

Үнэлгээний дараах гурван арга хандлагыг өргөн ашигладаг:

- Зах зээлийн хандлага - хөрөнгө өр төлбөртэй ижил буюу ижил төстэй хөрөнгө, өр төлбөрийн зах зээлийн үнэ ханшийн мэдээллийг ашиглах арга
- Зардлын хандлага - хөрөнгөтэй адил зорилгоор ашиглаж болох хөрөнгийг бий болгоход шаардагдах дүнг тодорхойлох арга (нөхөлтийн өнөөгийн өртөг)
- Орлогын хандлага - ирээдүйн мөнгөн гүйлгээ, орлого, зардлын дүнг дискаунтчиглан өнөөгийн үнэ цэнд хөрвүүлэх арга. Ингэж хөрвүүлэхдээ ирээдүйн дүнгийн талаарх өнөөгийн зах зээлийн хүлээлтийг харгалзан үзнэ.

Зарим нөхцөлд үнэлгээний зөвхөн нэг арга хандлагыг баримтлах нь тохиромжтой байдаг бол заримдаа хослуулан хэрэглэх нь илүү тохиромжтой байдаг.

Үнэлгээний арга нь тухайн үеийн зах зээлийн нөхцөл байдал, холбогдох эрсдэлийн үр нөлөө зэргийг харгалзан үзсэн байх бөгөөд дараах шинж чанарыг агуулсан байна. Үүнд:

- Зах зээлийн оролцогчид өргөн ашигладаг байх
- Эдийн засгийн тооцооллын хүлээн зөвшөөрөгдсөн арга техникт нийцсэн
- Зах зээлийн оролцогчид давамгайлж үздэг эх сурвалжид суурилсан
- Илэрхий байдаг тоон мэдээллийг аль болох өргөн ашигласан
- Зөвхөн тухайн аж ахуйн нэгжийн хувьд онцлог хүчин зүйлд аль болох бага тулгуурласан
- Зах зээлийн бодит хэлцэлд нийцүүлэн тогтмол баталгаажуулдаг

Зах зээлийн хандлагад нийцэх үнэлгээний аливаа арга нь ихэвчлэн зэрэгцүүлэгдэх үзүүлэлтүүдээс бүрдсэн зах зээлийн олонлогуудаас тохиромжтой олонлогийг сонгон ашигладаг. Тухайлбал: үнэ тогтоох матриц арга. Үнэ тогтоох матриц арга нь зөвхөн тодорхой хэдэн үнэт цаасны жишиг үнийг бус, харин уг үнэт цаасыг жишиг болох бусад үнэт цаастай холбож авч үзэх замаар өрийн үнэт цаас мэт зарим төрлийн санхүүгийн хэрэглүүрийг үнэлэхэд голчлон ашиглагддаг математикийн аргачлал юм.

Зардлын хандлагаар үнэлгээ хийхдээ хөрөнгийг худалдаж буй талын үүднээс үнэлгээг хийнэ. Худалдагч талын байр сууринаас зах зээлд оролцож буй үед хөрөнгийн худалдахад авах үнэ нь элэгдэл, хоцрогдлыг тохируулж гаргасан зэрэгцүүлэгдэх ашиглалт бүхий орлуулах хөрөнгийг худалдан авах буюу барьж байгуулахад гарах зардалд үндэслэнэ.

Орлогын хандлагаар үнэлгээ хийхдээ үнэлгээний дараах аргуудыг ашиглана. Үүнд:

- Өнөөгийн үнэ цэнийн арга буюу дискаунчилсан мөнгөн гүйлгээний шинжилгээ;
- Өнөөгийн үнэ цэнийн аргыг багтаасан бөгөөд аливаа опционы цаг хугацааны үнэ цэн болон дотоод үнэ цэнийг хоёуланг нь ашигладаг Блэк-Шолес, Мертоны томъёо эсхүл хоёр гишүүнт загвар гэх зэрэг опционы үнэлгээний загварууд;
- Зарим биет бус хөрөнгийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашиглагддаг олон тайлант үеийн илүүдэл ашгийн үнэлгээний арга.

3. ҮЛГЭРЧИЛСЭН ЖИШЭЭ

1. ХОМК санг үүсгэн байгуулах

ХОМК хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулж, холбогдох журмын дагуу 20,0 сая төгрөгийн анхны хувь нийлүүлсэн хөрөнгийг бүрдүүлэв. Анх байгуулах үеийн нэгж

эрхийн үнийг 1000 төгрөгөөр тогтоосон тул менежментийн компани 20,000 нэгж эрх эзэмшив.

Дебет: Банкинд байршуулсан харилцах 20,000 мянган төгрөг
Кредит: Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө 20,000 мянган төгрөг

Эхлэлийн баланс дараах байдалтай байна (мянган төгрөгөөр):

Хөрөнгө:		Өр төлбөр ба эздийн өмч:	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	20,000	Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	20,000
Нийт хөрөнгө	<u>20,000</u>	Эздийн өмчийн дүн	<u>20,000</u>

Тодруулга:

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	20,000
Гаргасан нэгж эрхийн тоо	20
Нэгж эрхийн үнэ	1000
Хөрөнгө оруулалтын менежметийн компанийн эзэмшиж буй нэгж эрхийн тоо	20
Менежментийн компанид ногдох цэвэр хөрөнгө	20,000
Нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгө	0

2. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх гаргах

Хөрөнгө оруулалтын сангийн танилцуулгыг олон нийтэд танилцуулан, 1000 төгрөгийн анхны үнэтэй, 180,000 ширхэг нэгж эрхээ санал болгон гаргав. Нэгж эрхийг 1000 төгрөгөөр арилжаалсан бөгөөд төлбөрийг мөнгөн хэлбэрээр хүлээн авчээ.

Нэгж эрх эзэмшигчдээс хүлээн авсан нийт дүн:
180000 ш * 1000 төг = 180 сая төгрөг

Дебет: Банкинд байршуулсан харилцах 180,000 мянган төгрөг
Кредит: Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө 180,000 мянган төгрөг

Энэ ажил гүйлгээний дараа санхүүгийн байдал өөрчлөгдөж, дараах байдалтай болно:

Хөрөнгө:		Өр төлбөр ба эздийн өмч:	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	200,000	Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	200,000
Нийт хөрөнгө	<u>200,000</u>	Эздийн өмчийн дүн	<u>200,000</u>

Тодруулга:

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	200,000
Гаргасан нэгж эрхийн тоо	200
Нэгж эрхийн үнэ	1000
Хөрөнгө оруулалтын менежметийн компанийн эзэмшиж буй нэгж эрхийн тоо	20
Менежментийн компанид ногдох цэвэр хөрөнгө	20,000
Нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгө	180,000

3. Санхүүгийн хэрэгслийг худалдан авах

Хөрөнгө оруулалтын сан 150 сая төгрөгийн зах зээлийн үнэ бүхий үнэт цаас худалдан авсан. Гүйлгээний шимтгэл 4,0 сая төгрөг.

Дебет: Үнэт цаас 150,000 мянган төгрөг
Дебет: Гүйлгээний шимтгэл 4,000 мянган төгрөг
Кредит: Банкинд байршуулсан харилцах 154,000 мянган төгрөг

Энэ ажил гүйлгээний дараа санхүүгийн байдал өөрчлөгдөж, дараах байдалтай болно:

Хөрөнгө:		Өр төлбөр ба эздийн өмч:	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	46,000	Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	200,000
Үнэт цаас	150,000	Хуваарилагдаагүй алдагдал	(4,000)
Нийт хөрөнгө	<u>196,000</u>	Эздийн өмчийн дүн	<u>196,000</u>

Тодруулга:

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	196,000
Гаргасан нэгж эрхийн тоо	200
Нэгж эрхийн үнэ	980
Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эзэмшиж буй нэгж эрхийн тоо	20
Менежментийн компанид ногдох цэвэр хөрөнгө	19,600
Нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгө	176,400

Орлогын тайлан:

Орлого	-
Зардал:	
Санхүүгийн зардал	4,000
Цэвэр алдагдал	<u>(4,000)</u>

4. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг тохируулах

Худалдан авсан үнэт цаасны зах зээлийн үнэ өсөж 156 сая төгрөг болсон, өөрөөр хэлбэл 6,0 сая төгрөгөөр өссөн.

Дebet: Үнэт цаас	6,000 мянган төгрөг
Кредит: Үнэт цаасны үнэлгээний олз	6,000 мянган төгрөг

Энэ ажил гүйлгээний дараа санхүүгийн байдал өөрчлөгдөж, дараах байдалтай болно:

Хөрөнгө:		Өр төлбөр ба эздийн өмч:	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	46,000	Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	200,000
Үнэт цаас	156,000	Хуваарилагдаагүй ашиг	2,000
Нийт хөрөнгө	<u>202,000</u>	Эздийн өмчийн дүн	<u>202,000</u>

Тодруулга:

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	202,000
Гаргасан нэгж эрхийн тоо	200
Нэгж эрхийн үнэ	1010
Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эзэмшиж буй нэгж эрхийн тоо	20
Менежментийн компанид ногдох цэвэр хөрөнгө	20,200
Нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгө	181,800

Орлогын тайлан:

Орлого	-
Үнэлгээний олз	6,000
Зардал	-
Цэвэр ашиг	<u>6,000</u>

5. Санхүүгийн хэрэгслийг худалдах

Зах зээлийн үнэ өсөлттэй байгаа учраас сан 56 сая төгрөгийн дансны үнэтэй үнэт цаасыг 60 сая төгрөгөөр худалдсан. Үлдэж буй үнэт цаасны зах зээлийн бодит үнэ цэн 105 сая төгрөг.

Үнэт цаасны эхний үлдэгдэл 156 сая төгрөг байсан бөгөөд үүнээс 56 сая төгрөгийн үнэт цаасыг 60 сая төгрөгөөр зарж, 4 сая төгрөгийн ашиг олсон ба үлдэж буй 100,0 сая төгрөгийн дансны үнэтэй санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэн (156 өмнөх өдрийн үлдэгдэл -56 зарсан) буюу дансны үнэ нь 105 сая төгрөг болж өссөний улмаас дахин 5 сая төгрөгийн нэмэлт ашиг олсон байна.

Дебет: Банкинд байршуулсан харилцах 60,000 мянган төгрөг
Кредит: Үнэт цаас 56,000 мянган төгрөг
Кредит: Үнэт цаасны арилжааны олз 4,000 мянган төгрөг

Үлдэж буй үнэт цаасны хувьд бодит үнэлгээний залруулга хийхдээ:

Дебет: Үнэт цаас 5,000 мянган төгрөг
Кредит: Үнэт цаасны 5,000 мянган төгрөг

Энэ ажил гүйлгээний дараа санхүүгийн байдал өөрчлөгдөж, дараах байдалтай болно:

Хөрөнгө:		Өр төлбөр ба эздийн өмч:	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	46,000	Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	202,000
Брокероос авах авлага	60,000	Хуваарилагдаагүй ашиг	9,000
Үнэт цаас	105,000		
Нийт хөрөнгө	<u>211,000</u>	Эздийн өмчийн дүн	<u>211,000</u>

Тодруулга:

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	211,000
Гаргасан нэгж эрхийн тоо	200
Нэгж эрхийн үнэ	1055
Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эзэмшиж буй нэгж эрхийн тоо	20
Менежментийн компанид ногдох цэвэр хөрөнгө	21,100
Нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгө	189,900

Орлогын тайлан:

Орлого	-
Үнэлгээний олз	5,000
Арилжааны олз	4,000
Зардал	-
Цэвэр ашиг	<u>9,000</u>

6. Ногдол ашгийн орлого

Хэрэв хөрөнгө оруулалтын сангийн багцад байгаа хувьцааг гаргасан компани ногдол ашиг хуваарилахаар зарласан бол ногдол ашгийг төлөөгүй байгаа ч гэсэн зарласан үед нь орлого болгон бүртгэж, нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгийг нэмэгдүүлнэ.

Зарласан ногдол ашиг 3 сая төгрөг бол дараах бичилт хийгдэнэ:

Дебет: Ногдол ашгийн авлага 3,000
Кредит: Ногдол ашгийн орлого 3,000

Энэ ажил гүйлгээний дараа санхүүгийн байдал өөрчлөгдөж, дараах байдалтай болно:

Хөрөнгө:		Өр төлбөр ба эздийн өмч:	
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	46,000	Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	211,000
Брокероос авах авлага	60,000	Хуваарилагдаагүй ашиг	3,000
Ногдол ашгийн авлага	3,000		
Үнэт цаас	105,000		
Нийт хөрөнгө	<u>214,000</u>	Эздийн өмчийн дүн	<u>214,000</u>

Тодруулга:

Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	214,000
Гаргасан нэгж эрхийн тоо	200
Нэгж эрхийн үнэ	1070
Хөрөнгө оруулалтын менежментийн компанийн эзэмшиж буй нэгж эрхийн тоо	20
Менежментийн компанид ногдох цэвэр хөрөнгө	21,400
Нэгж эрх эзэмшигчдэд ногдох цэвэр хөрөнгө	192,600

Орлогын тайлан:

Орлого:	
Ногдол ашгийн орлого	3,000
Зардал	-
Цэвэр ашиг	3,000

7. Тухайн хугацаанд ногдох зардлын дүнг оруулан цэвэр хөрөнгийн өртгийг тооцоолох

Тухайн өдрийн ЦХӨ (t=0) 1 тэрбум байв. Үйлчилгээний зардлын хувь жилд дунджаар 3%. Сангийн дүрмээр нэгж эрхээ өдөр бүр эргүүлэн худалдан авна гэвэл үйлчилгээний зардлын өдрийн дундаж дүн нь:

$$(1 \text{ тэрбум}) \times (3\%) \times (1/365) = 82,191,780$$

Дараагийн өдрийн цэвэр хөрөнгө (t=1) 1.1 тэрбум бол үйлчилгээний зардлын өдрийн дундаж дүн нь:

$$(1.1 \text{ тэрбум}) \times (3\%) \times (1/365) = 90,410,959$$

Нэг өдөрт ногдох зардлыг ийнхүү тооцоолж, тухайн өдөр хүртэл тооцоолсон өр төлбөрийн дүнд оруулна.

Тухайн өдөр хүртэл тооцоолсон нийт өр төлбөрийн дүн:

$$82,191,780 + 90,410,959 = 172,602,739$$

Цэвэр хөрөнгийн дундаж үлдэгдэлд ногдуулан тооцсон үйлчилгээний зардлын төлбөл зохих дүн:

$$(1 \text{ тэрбум} + 1.1 \text{ тэрбум}) / 2 \times 39 \times 2 \text{ өдөр} / 365$$

Хэрэв дараах өдрийн цэвэр хөрөнгө (t=1) 0.9 тэрбум бол үйлчилгээний зардлын өдрийн дундаж дүн нь:

$$(0.9 \text{ тэрбум}) \times (3\%) \times (1 / 365) = 73,972,602$$

Тухайн өдөр хүртэл тооцоолсон нийт өр төлбөрийн дүн:

$$82,191,780 + 90,410.959 + 73,972,602 = 246,575,341$$

Цэвэр хөрөнгийн дундаж үлдэгдэлд ногдуулан тооцсон үйлчилгээний зардлын төлбөл зохих дүн:

$$(1 \text{ тэрбум} + 1.1 \text{ тэрбум} + 0.9 \text{ тэрбум}) / 3 \times 3\% \times 3 \text{ өдөр} / 365$$

Ийм маягаар өдөр бүр сангийн хөрөнгийн дундаж үлдэгдлийг тооцон, тухайн өдөр хүртэл хугацаанд оногдох зардлын төлбөл зохих дүнг тооцон, цэвэр хөрөнгийн тооцоонд оруулна.

Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын
 2015 оны 12 дугаар сарын 0...-ны өдрийн 328.../326... тоот
 хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН САНГИЙН ДАНСНЫ ЖИШИГ ЖАГСААЛТ

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	1XXX	
2	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	1000-1100	
	Касс дахь бэлэн мөнгө	1001	
	Банкинд байршуулсан харилцах	1102	
	Банкинд байршуулсан хадгаламж	1103	
	Мөнгөтэй адилтгах хөрөнгө	1104	
3	Бусдаас авах авлага	1200	
	ХОМК-аас авах авлага	1201	
	Кастодианаас авах авлага	1202	
	Ногдол ашгийн авлага	1203	
	Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага	1204	
	Бусад авлага	1205	
	Авлагын эрсдэлийн сан	1206	
4	Урвуу репо	1300	
	Анхны өртөг	1301	
	Эрсдэлийн сан	1302	
5	Татварын авлага	1400	
	ААНОАТ-ын авлага	1401	
	ХХОАТ-ын авлага	1402	
	НӨАТ-ын авлага	1403	
	Бусад татварын авлага	1404	
6	Үнэт цаас	1500	
	Засгийн газрын өрийн хэрэгсэл	1510	
	Анхны өртөг	1511	
	Үнийн өсөлт, бууралт	1512	
	Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэл	1520	
	Анхны өртөг	1521	
	Үнийн өсөлт, бууралт	1522	
	Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл	1530	
	Анхны өртөг	1531	
	Үнийн өсөлт, бууралт	1532	
	Хувьцаат компанийн хувьцаа	1540	
	Анхны өртөг	1541	
	Үнийн өсөлт, бууралт	1542	
	Компанийн өрийн хэрэгсэл	1550	
	Анхны өртөг	1551	
	Үнийн өсөлт, бууралт	1552	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1560	
	Анхны өртөг	1561	
	Үнийн өсөлт, бууралт	1562	
	Гадаадын үнэт цаас	1570	
	Анхны өртөг	1571	
	Үнийн өсөлт, бууралт	1572	
	Бусад өрийн хэрэгсэл	1580	

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
	Анхны өртөг	1581	
	Үнийн өсөлт, бууралт	1582	
	Бусад өмчийн хэрэгсэл	1590	
	Анхны өртөг	1591	
	Үнийн өсөлт, бууралт	1592	
7	Барьцаанд тавьсан үнэт цаас	1600	
	Засгийн газрын өрийн хэрэгсэл	1610	
	Анхны өртөг	1611	
	Үнийн өсөлт, бууралт	1612	
	Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэл	1620	
	Анхны өртөг	1621	
	Үнийн өсөлт, бууралт	1622	
	Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл	1630	
	Анхны өртөг	1631	
	Үнийн өсөлт, бууралт	1632	
	Хувьцаат компанийн хувьцаа	1640	
	Анхны өртөг	1641	
	Үнийн өсөлт, бууралт	1642	
	Компанийн өрийн хэрэгсэл	1650	
	Анхны өртөг	1651	
	Үнийн өсөлт, бууралт	1652	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	1660	
	Анхны өртөг	1661	
	Үнийн өсөлт, бууралт	1662	
	Гадаадын үнэт цаас	1670	
	Анхны өртөг	1671	
	Үнийн өсөлт, бууралт	1672	
	Бусад өрийн хэрэгсэл	1680	
	Анхны өртөг	1681	
	Үнийн өсөлт, бууралт	1682	
	Бусад өмчийн хэрэгсэл	1690	
	Анхны өртөг	1691	
	Үнийн өсөлт, бууралт	1692	
8	Дериватив хөрөнгө	1700	
	Фьючерс хэлцэл	1710	
	Форвард хэлцэл	1720	
	Своп хэлцэл	1730	
	Опцион	1740	
	Бусад	1750	
9	Урьдчилж төлсөн тооцоо	1800	
	Урьдчилгаа төлбөр	1801	
	Дэнчин	1802	
	Барьцаанд тавьсан хөрөнгө	1803	
	Урьдчилж төлсөн тооцоо	1804	
	Бусад	1805	
10	Бусад эргэлтийн хөрөнгө	1900	
	Уул уурхайн бүтээгдэхүүн	1901	
	Бусад	1902	
11	Хойшлогдсон татварын хөрөнгө	2000	
12	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	2100	

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
	Анхны өртөг	2101	
	Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт	2102	
	Үнийн өсөлт, бууралт	2103	
13	Бусад эргэлтийн бус хөрөнгө	2200	
	Анхны өртөг	2201	
	Хуримтлагдсан элэгдэл, үнэ цэнийн бууралт	2202	
	Үнийн өсөлт, бууралт	2203	
14	ӨР ТӨЛБӨР	3XXX	
15	Бусад өгөх өглөг	3100	
	ХОМК-д өгөх өглөг	3101	
	Кастодианд өгөх өглөг	3102	
	Мэргэжлийн үйлчилгээний өглөг	3103	
	Брокерт төлөх өглөг	3104	
	Төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний өглөг	3105	
	Бүртгэлийн үйлчилгээний өглөг	3106	
	Үнэлгээний ажлын өглөг	3107	
	Ногдол ашгийн өглөг	3108	
	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	3109	
	Хуримтлуулан тооцоолсон бусад өглөг	3110	
16	Гаргасан репо хэрэгсэл	3200	
17	Татварын өглөг	3300	
	ААНОАТ-ын өглөг	3301	
	ХХОАТ-ын өглөг	3302	
	НӨАТ-ын өглөг	3303	
	Бусад татварын өглөг	3304	
		3400	
18	Гаргасан өрийн хэрэгсэл		
	Өрийн бичиг	3410	
	Анхны өртөг	3411	
	Үнийн өсөлт, бууралт	3412	
	Вексель	3420	
	Анхны өртөг	3421	
	Үнийн өсөлт, бууралт	3422	
	Бонд	3430	
	Анхны өртөг	3431	
	Үнийн өсөлт, бууралт	3432	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	3440	
	Анхны өртөг	3441	
	Үнийн өсөлт, бууралт	3442	
	Бусад	3450	
	Анхны өртөг	3451	
	Үнийн өсөлт, бууралт	3452	
19	Дериватив өр төлбөр	3500	
	Фьючерс хэлцэл	3510	
	Форвард хэлцэл	3520	
	Своп хэлцэл	3530	
	Опцион	3540	
	Бусад	3550	
20	Өр төлбөрт бүртгэсэн нэгж эрх	3600	
21	Хойшлогдсон татварын өглөг	3700	

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
22	ЦЭВЭР ХӨРӨНГӨ	4XXX	
23	Нэгж эрх эзэмшигчдийн цэвэр хөрөнгө	4100	
24	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	4200	
25	ОРЛОГО	5XXX	
26	Хөрөнгө оруулалтын орлого	5100	
	Хүүгийн орлого	5110	
	Засгийн газрын өрийн хэрэгсэлийн	5111	
	Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэлийн	5112	
	Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэлийн	5113	
	Компанийн өрийн хэрэгсэлийн	5114	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны	5115	
	Гадаадын үнэт цаасны	5116	
	Бусад өрийн хэрэгсэл	5117	
	Ногдол ашгийн орлого	5120	
	Хувьцаат компанийн хувьцааны	5121	
	Бусад өмчийн хэрэгсэлийн	5122	
	Түрээсийн орлого	5130	
27	Бусад орлого	5200	
	Татаас, санхүүжилтын орлого	5201	
	Бусад	5202	
28	ОЛЗ, ГАРЗ	6XXX	
	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз, гарз	6110	
	Санхүүгийн хэрэгслийн үнэлгээний олз, гарз	6120	
	Үнэт цаасны үнэлгээний олз, гарз	6121	
	Деривативын үнэлгээний олз, гарз	6122	
	Гаргасан өрийн хэрэгслийн үнэлгээний олз, гарз	6123	
	Бусад	6124	
	Санхүүгийн хэрэгслийн арилжааны олз, гарз	6130	
	Үнэт цаасны арилжааны олз, гарз	6131	
	Деривативын арилжааны олз, гарз	6132	
	Гаргасан өрийн хэрэгслийн арилжааны олз, гарз	6133	
	Бусад	6134	
	Хөрөнгийн дахин үнэлгээний олз, гарз	6140	
	Бусад олз, гарз	6150	
29	ЗАРДАЛ	7XXX	
30	Ерөнхий удирдлагын зардал	7100	
	ХОМК-ийн үйлчилгээний зардал	7101	
	Кастодианы үйлчилгээний зардал	7102	
	Мэргэжлийн үйлчилгээний зардал	7103	
	Төлбөр тооцоо гүйцэтгэх үйлчилгээний зардал	7104	
	Бүртгэлийн үйлчилгээний зардал	7105	
	Үнэлгээний зардал	7106	
31	Санхүүгийн зардал	7200	
	Ажил гүйлгээний зардал	7210	
	Хүүгийн зардал	7220	
	Өрийн бичгийн	7221	
	Вексель	7222	

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
	Бондын	7223	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны	7224	
	Бусад	7225	
32	Бусад зардал	7300	
	Ногдол ашгийн зардал	7301	
	Гүйцэтгэлийн урамшуулал	7302	
	Алданги, торгуулийн зардал	7303	
	Бусад	7304	
33	Орлогын албан татварын зардал	7400	
	Тайлант үеийн орлогын албан татварын зардал	7410	
	Хойшлогдсон татварын зардал	7420	
34	ТЭНЦЛИЙН БУСАД ДАНСД	8XXX	
	Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	8100	
	Орлого, зардлын нэгдсэн данс	8200	
35	ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ДАНСД	9XXX	
	Хүлээсэн болзошгүй үүрэг	9100	
	Барьцаа хөрөнгө	9200	
	Үнэт цаас	9210	
	Засгийн газрын өрийн хэрэгсэл	9211	
	Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэл	9212	
	Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл	9213	
	Хувьцаат компанийн хувьцаа	9214	
	Компанийн өрийн хэрэгсэл	9215	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	9216	
	Гадаадын үнэт цаас	9217	
	Бусад өрийн хэрэгсэл	9218	
	Бусад өмчийн хэрэгсэл	9219	
	Үл хөдлөх хөрөнгө	9220	
	Орон сууц	9221	
	Оффисын барилга	9222	
	Байгууламж	9223	
	Бусад үл хөдлөх хөрөнгө	9224	
	Бусад хөрөнгө	9230	
	Дериватив санхүүгийн хэрэгсэл	9300	
	Фьючерс хэлцэл	9310	
	Арилжааны авлага	9311	
	Арилжааны өглөг	9312	
	Форвард хэлцэл	9320	
	Арилжааны авлага	9321	
	Арилжааны өглөг	9322	
	Своп хэлцэл	9330	
	Арилжааны авлага	9331	
	Арилжааны өглөг	9332	
	Опцион	9340	
	Арилжааны авлага	9341	
	Арилжааны өглөг	9342	
	Бусад	9350	
	Арилжааны авлага	9351	

д/д	Дансны бүлэг, нэр	Дансны код	Үлдэгдэл
	Арилжааны өглөг	9352	
	Барьцаанд тавьсан хөрөнгө	9400	
	Үнэт цаас	9410	
	Засгийн газрын өрийн хэрэгсэл	9411	
	Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэл	9412	
	Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл	9413	
	Хувьцаат компанийн хувьцаа	9414	
	Компанийн өрийн хэрэгсэл	9415	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	9416	
	Гадаадын үнэт цаас	9417	
	Бусад өрийн хэрэгсэл	9418	
	Бусад өмчийн хэрэгсэл	9419	
	Үл хөдлөх хөрөнгө	9420	
	Орон сууц	9421	
	Оффисын барилга	9422	
	Байгууламж	9423	
	Бусад үл хөдлөх хөрөнгө	9425	
	Бусад хөрөнгө	9430	
	Бусад дансд	9500	
	Эзэмшиж буй үнэт цаас	9510	
	Засгийн газрын өрийн хэрэгсэл	9511	
	Засгийн газрын баталгаатай өрийн хэрэгсэл	9512	
	Аймаг, нийслэлийн Засаг даргын гаргасан өрийн хэрэгсэл	9513	
	Хувьцаат компанийн хувьцаа	9514	
	Компанийн өрийн хэрэгсэл	9515	
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	9516	
	Гадаадын үнэт цаас	9517	
	Бусад өрийн хэрэгсэл	9518	
	Бусад өмчийн хэрэгсэл	9519	
	Үл хөдлөх хөрөнгө	9520	
	Орон сууц	9521	
	Оффисын барилга	9522	
	Байгууламж	9523	
	Бусад үл хөдлөх хөрөнгө	9524	
	Бусад хөрөнгө	9530	